

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**  
(2021 оны жилийн эцсийн байдлаар)

2022.01.16

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй**

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалыг удирдлага болгов.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2 бодлогын 5 тэргүүлэх зорилтод хамаарах нийт 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнгээр тайлагнав. Нийт 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг ТӨБЗГ-т хяналтад авч, хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

ТӨБЗГ нь хариуцан хэрэгжүүлэх 12 арга хэмжээний 11 арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар, 1 арга хэмжээ (4.4.10.1.)-ний хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар үүрэг хүлээсэн.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2-ыг удирдлага болгон хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн бөгөөд зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрч, үр дүнтэй хэрэгжсэн арга хэмжээг 100.0 хувиар үнэлж тооцсон.

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайланг хавсралт – 1, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг хавсралт – 2-оор тайлагнав.

**Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:**

*Бодлого, арга хэмжээгээр харуулбал:*

- Эдийн засгийн бодлогын 2 зорилтын 3 арга хэмжээ 76.6 хувь;
- Засаглалын бодлогын 3 зорилтын 9 арга хэмжээ 96.7 хувь.

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ – **91.7%** буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

д/д	Хэрэгжилт	Бүгд	Бодлого	
			Эдийн засаг	Засаглал
1	Хяналтад авсан зорилтын тоо	5	2	3
2	Хяналтад авсан арга хэмжээний тоо	12	3	9
3	Үнэлгээний хувь	100.0 хувь		6
4		90.0 хувь	1	3
5		70.0 хувь	2	-
6		50.0 хувь	-	-
7		30.0 хувь	-	-
8		0.0 хувь	-	-
9	<b>Хэрэгжилтийн хувь</b>	<b>91.7 хувь</b>	<b>76.6 хувь</b>	<b>96.7 хувь</b>

Үндсэн хэрэгжүүлэх нэгжээр нь харуулбал:

- Бүх хэлтэс, албад хамааралтай 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувь;
- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс 2 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт 86.0 хувь;
- Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь;
- Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь;
- Хууль, эрх зүйн хэлтэс 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувьтай байна.

д/д	Хэрэгжилт	Бүгд	Хэлтэс				
			Бүх хэлтэс, албад хамааралтай	ТӨУХэлтэс	ТӨБАХэлтэс МТА	ТӨХШХэлтэс	ХЭЗХэлтэс
1	Хяналтад авсан арга хэмжээний тоо	12	1	5	2	2	2
2	Үнэлгээний хувь	100.0 хувь	6	-	2	2	-
3		90.0 хувь	4	1	1	-	2
4		70.0 хувь	2	-	2	-	-
5		50.0 хувь	-	-	-	-	-
6		30.0 хувь	-	-	-	-	-
7		0.0 хувь	-	-	-	-	-
8	<b>Хэрэгжилтийн хувь</b>	<b>91.7 хувь</b>	<b>90.0 хувь</b>	<b>86.0 хувь</b>	<b>100.0 хувь</b>	<b>100.0 хувь</b>	<b>90.0 хувь</b>

2021 оны жилийн эцсийн үнэлгээг эхний хагас жил болон ЗГХЭГ-ын III улирлын байдлаар харьцуулвал:



- 2021 оны эхний хагас жил
- 2021 оны жилийн эцэс
- ЗГХЭГ-ын үнэлгээ (2021 оны III улирал)

**Хэрэгжилт сайтай, тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээнүүдээс дурдвал:**

- 4.1.4.5.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно; Санхүүжилт- 1.2 тэрбум төгрөг шийдвэрлүүлсэн;
  - 4.4.10.5.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина гэсэн арга хэмжээний хүрээнд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж өгөх; Санхүүжилт- 358.3 сая төгрөг шийдвэрлүүлсэн;
  - 4.4.10.3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ. Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр Олон Улсын байгууллагуудаас зөвлөмж чиглэл авч, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэр, засаглалыг сайжруулах загвар төслийг боловсруулсан. Компанийн засаглалын олон улсын туршлага, Төрийн өмчийн баялгийн сан, корпорацийн засаглал, үйл ажиллагааны бүтцийг Казакстаны САМРУК КАЗИНА, БНХАУ-ын SASAC, Сингапур улсын ТЭМАСЕК Холдинг зэрэг корпорациудын засаглал, үйл ажиллагааны бүтэц, өмчлөлийн байдал, Fortune global 500 буюу дэлхийн шилдэг 500 компанийн жагсаалт зэргийг судалсан. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Санхүү, эдийн засгийн их сургууль, "Компанийн засаглалын хөгжлийн төв" ТББ-тай хамтран ажиллаж, нэр бүхий төрийн өмчит 7 компанийн засаглалын үнэлгээг хийлгэсэн. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 53.9 хувь байсан бол тайлант онд 64.8 хувьд хүрсэн үр дүнтэй;
  - 4.4.10.4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна. Тухайн зорилт, арга хэмжээ 2022 оноос хэрэгжиж эхэлнэ. ТӨБЗГ-аас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа төрийн өмчит 46 компани, үйлдвэрийн газрууд хэмнэлтийн горимд ажилласнаар 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал 0.67 төгрөг болж, 2021 оны төлөвлөгөө 0.82 төгрөгөөс 0.15 төгрөгөөр буюу 18.14 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд 209.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөг 115 хувиар давуулан биелүүлсэн;
  - 4.2.4.2.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна. Тайлант онд дэвшүүлсэн зорилтот түвшиндээ хүрч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 27 хуулийн этгээд хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хяналт шалгалтын тайлангийн баталгаажсан дүнгээр 12.490.74 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчил арилгах асуудалтай холбоотойгоор цаашид авч хэрэгжүүлэх нийт 90 арга хэмжээ, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах 86 арга хэмжээ бүхий үүрэг даалгаврыг эрх бүхий албан хаагчдад хүргүүлэн, 69 ажилтанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан;
  - 4.2.4.3.Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 11 төсөвт байгууллагад системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, 9 хуулийн этгээдэд нийт 1,268.12 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн.
- Тайлант хугацаанд тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хамаарах шийдвэрийг гаргаж, дээд шатны байгууллагуудаас болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудаас хамаарч 70 хувиар үнэлэгдсэн дараах арга хэмжээнүүд байна. Үүнд:
- 3.2.7.6."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.

- 3.7.8.1. Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.

**Гурав. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/**

1. Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хүрэх түвшингийн үр дүнгийн хэрэгжилтээр ямар үр дүн гарсныг, үр ашиг яаж дээшилсэн талаар өмнөх онтой харьцуулан өссөн буурсан үзүүлэлтээр тайлагнаж байх.

**Шийдвэрлүүлэх асуудал /Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын түвшинд/**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний:

- 4.1.4.1. Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбох арга хэмжээ нь ТӨБЗГазарт хамаарах заалт биш учраас Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn-нээс хасалт хийлгүүлэх саналтай байна.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА **Б.ЦЭНГЭЛ**

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА **Н.ГАНБОЛД**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
МЭРГЭЖИЛТЭН **Д.ЦЭРЭНЛХАМ**